



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/165

Хэрлэн сум

Мэдээ, мэдээлэл дамжуулах ажилд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ард иргэдэд болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл дамжуулах ажлыг зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтэд хүртээмжтэй бүхий л төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 21-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Дүн
1	Багц мессэж	3,000,000
2	Радио холбоо	5,000,000
	Нийт	8,000,000